

# Саадтай гүйлт

Дан саадтай гүйлт бүхий видео тоглоом тоглож байгаа бөгөөд түүнд дараах тооцоолол хийх шаардлага тулгарсан.

Саадуудын өндөр харилцан адилгүй өөр өөр өндрүүдтэй бөгөөд тоглогчийн хувьд түүний харайж чадах хамгийн

их өндрийн хэмжээ мэдэгдэж байгаа.

Түүнд мөн шидэт жүүс байгаа бөгөөд түүнээс нэг тунг уухад түүний харайж чадах өндрийн хэмжээ 1 нэгжээр нэмэгддэг.

Тэгвэл түүний хувьд бүх саадуудыг давж чадахын тулд хамгийн багадаа хэдэн тун жүүс уухыг тооцоолно уу?

Тухайлбал өндрүүдийн хэмжээ 1,2,3,3,2 гэж өгөгдсөн ба түүний харайж чадах хамгийн их өндрийн хэмжээ 1 бол тэр

$3 - 1 = 2$  буюу 2 тун хэмжээтэй жүүс уух шаардлагатай болно гэсэн үг.

## Оролтын хэлбэр:

Эхний мөрөнд  $n, k$  тоонууд өгөгдөх бөгөөд харгалзан саадны тоо болон түүний харайж чадах хамгийн их өндрийн хэмжээ.

Дараагийн мөрөнд  $N$  ширхэг саадны өндрийн хэмжээ өгөгдөнө.

## Хязгаарлалт:

$1 \leq n, k \leq 100$

$1 \leq \text{өндрүүд} \leq 100$ .

## Гаралтын хэлбэр:

Бүх саадыг давж гарахад шаардлагатай шидэт жүүснээс уух хамгийн бага тунгийн хэмжээг хэвлэнэ.

## Жишээ Оролт 0


5 4

1 6 3 5 2

## Жишээ Гаралт 0

2

## Тайлбар 0



Түүний харайж чадах хамгийн их өндрийн хэмжээ  $k=4$  ба саадны хамгийн өндөр нь 6 тул тэр  $6 - 4 = 2$  буюу 2 тун шидэд жүүс уухад бүх саадуудыг давах чадвартай болно.

#### Жишээ Оролт 1


5 7

2 5 4 5 2

#### Жишээ Гаралт 1

0

#### Тайлбар 1



Түүний харайж чадах өндрийн хэмжээ  $k=7$  тул бүх саадыг давж чадах тул шидэт жүүснээс уух шаардлагагүй.

